



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/188

Мяндалговь

“Гурван дэлгэр” ХХК-тай нэмэлт
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 34 дүгээр зүйлийн 34.2, 34.1.4 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Цэцэрлэгийн барилга (Өндөршил сум)” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Гурван дэлгэр” ХХК-тай байгуулсан БСШУСЯ/201902159-ны дугаартай 933,785,302 (есөн зуун гучин гурван сая долоон зуун наян таван мянга гурван зуун хоёр) төгрөгийн гэрээний дүнг 66,214,698 (жаран зургаан сая хоёр зуун арван дөрвөн мянга зургаан зуун ерэн найм) төгрөгөөр нэмэлт гэрээ байгуулсугай.

Хоёр. Нэмэлт батлагдсан зураг төсвийн дагуу “Цэцэрлэгийн барилга (Өндөршил сум)” ажлыг чанартай хийж гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Гурван дэлгэр” ХХК-ийн захирал (Ш.Цэцэгмаа)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Өндөршил сумын Засаг дарга (Л.Мөнхбадрах), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010519